САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 10 өдөр Дугаар 197 Улаанбаатар хот

"АПУ" ХК-ийн үнэт цаасны бүртгэлд
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.6, 3 дугаар 3.3.1, 5 дугаар зүйлийн 5.1.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."АПУ" ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 74,287,700 /далан дөрвөн сая хоёр зуун наян долоон мянга долоон зуун/ ширхэг хувьцааг 10 хуваж нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэ бүхий 742,877,000 /долоон зуун дөчин хоёр сая найман зуун далан долоон мянган/ ширхэг энгийн хувьцаа болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг "ҮЦТХТ" ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2."АПУ" ХК-ийн хувьцааг хуваахтай холбоотой ажиллагааг ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэж, холбогдох тайланг ирүүлэхийг "МХБ" ХК /М.Болор/, "ҮЦТХТ" ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА Э.БАТБОЛД